



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

II сар

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны баг:

М.Түвшинжаргал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Хууль зүйн ухааны магистр (LL.M)

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан

Г.Болор-Эрдэнэ

Эрдэм шинжилгээний ажилтан

ТОВЧЛОЛ

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл, заалт.....	7
Хүснэгт 2. Төрийн байгууллагын стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь	11
Хүснэгт 3. Төрийн байгууллагын гүйцэтгэх стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	17
Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	23
Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал.....	24
Хүснэгт 6. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал	25
Хүснэгт 7. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал	25
Хүснэгт 8. Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээллийн жагсаалт /сангийн төрлөөр/	28
Хүснэгт 9. Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа	33
Хүснэгт 10. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа.....	37
Хүснэгт 11. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны зардал	38
Хүснэгт 12. Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тохиолдлын тоо	39
Хүснэгт 13. Иргэний нийгмийн байгууллагын тохиолдлын тоо	40
Хүснэгт 14. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагааны тоон үзүүлэлт	40
Хүснэгт 15. Хуулийн этгээдэд үүсэх нийт зардал	41

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	5
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	6
2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	11
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	17
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	23
2.4. Үр дүнг тооцох	24
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.	25
III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	28
3.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;	28
3.2 Зардал тооцох	36
3.3. Тоон үзүүлэлтийг тооцох	39
3.4. Зардлын дүнг тооцож гаргах	41
3.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	42
3.6. Нэмэлт зардлыг тооцох	43
IV ДҮГНЭЛТ, САНАЛ	44

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д “Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6.5-д “олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 130-д “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхээр “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль”-ийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулжээ.

Хуулийн төслөөр олборлох үйлдвэрлэлд хамаарах салбарыг тодорхойлох, тэдгээрийн нээлттэй мэдээллийг бүрдүүлсэн мэдээллийн сан бий болгох, олон талт бүлэг болон оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг голлон зохицуулжээ.

Энэхүү судалгаагаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зардлыг тооцох, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахыг зорилоо.

Тус хуулийн төсөлд иргэнд үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул энэхүү зардлын тооцооны судалгааг дараах үндсэн бүтцийн дагуу гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо
2. Хуулийн этгээдийн зардлын тооцоо

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг зардлын тооцоонд оруулахгүй. Үүнд:

- ❖ 6.7 дахь хэсэг. Мэдээллийн санд мэдээлэл оруулах хугацаа, маягт, журам, мэдээллийг мэдээллийн санд оруулах хэлбэр, шаардлага, цахимаар баримтжуулан хадгалах журмыг энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан Үндэсний зөвлөл батална.
- ❖ 12.1 дэх хэсэг. Энэ хуульд заасан мэдээллийг ил тод байлгах, мэдээллийн санд оруулах, тус мэдээллээр ил тод байдлын тайлан гаргах үүрэг бүхий этгээд /цаашид “мэдээлэл нийлүүлэгч” гэх/-ийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраас тогтооно.
- ❖ 12.5 дахь хэсэг. Энэ хуулийн 12.3-т заасан мэдээлэл нийлүүлэгчийг бүртгэх, баталгаажуулах журмыг энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан Үндэсний зөвлөл батална.
- ❖ 13.4 дэх хэсэг. Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн санд хандах, нэвтрэх, энэ хуулийн 14.7.10-т заасан нэгдсэн порталд холбох журмыг Засгийн газар батална.
- ❖ 13.7 дахь хэсэг. Энэ хуулийн 13.6-д заасан мэдээллийг тодорхой хугацаагаар түр нууцлах журам, хугацааг Засгийн газар батална.
- ❖ 13.8 дахь хэсэг. Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сан нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай холбогдсон байх бөгөөд мэдээлэл харилцан солилцох, ашиглах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 13.1, 13.2-т заасан төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.
- ❖ 14.9 дэх хэсэг. Салбар зөвлөлийн ажиллах журам, бүтэц, чиг үүрэг, бүрэлдэхүүнийг Үндэсний зөвлөл батална.
- ❖ 22.2 дахь хэсэг. Ажлын алба нь Үндэсний зөвлөл, түүний бүтцийн байгууллагын үйл ажиллагааны жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.
- ❖ 14.7.9 дэх хэсэг. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, заавар, маягт, зөвлөмж батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

Хүснэгт 1. Төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл, заалт

<p>Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт</p>	<p>Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт</p>
<p>23.1.Улсын Их Хурлаас олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 23.1.1.Засгийн газраас хүргүүлсэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх.</p>	
<p>24.1.Засгийн газар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.1.1.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 24.1.2.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг салбар тус бүрээр хэлэлцэн, шаардлагатай арга хэмжээний саналын хамт 8 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд хүргүүлэх; 24.1.3.энэ хуулийн 23.1.1-д заасан Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн биелэлтийг хангах арга хэмжээ авах.</p> <p>12.1.Энэ хуульд заасан мэдээллийг ил тод байлгах, мэдээллийн санд оруулах, тус мэдээллээр ил тод байдлын тайлан гаргах үүрэг бүхий этгээд /цаашид “мэдээлэл нийлүүлэгч” гэх/-ийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраас тогтооно.</p>	<p>6.1.Олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн сан нь дараах төрөлтэй байна:</p> <p>6.1.1.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны; 6.1.2.үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны; 6.1.3.ойн баялаг ашиглах үйл ажиллагааны; 6.1.4.амьтан агнах, барих үйл ажиллагааны; 6.1.5.байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны.</p>
<p>14.7.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.7.1.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан салбар бүрээр хэлэлцэх, олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх; 14.7.2.олборлох үйлдвэрлэлд үйл ажиллагаатай холбогдуулан төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, иргэн, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, хоорондын зохистой харилцаа, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг дэмжих; 14.7.3.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг үндэслэн авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон зөвлөмж гаргах, зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар шаардах, хариу, мэдээлэл авах;</p>	<p>14.1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хяналт тавих, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах чиг үүрэг бүхий, төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Үндэсний зөвлөл нь Ерөнхий сайдын дэргэд ажиллана.</p>

14.7.4.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;

14.7.5.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;

14.7.6.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой санал боловсруулж, төрийн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;

14.7.7.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, хяналт тавих, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах;

14.7.8.энэ хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа тайлан гаргагч зөвшөөрөл эзэмшигч болон төр, иргэний нийгмийн байгууллагыг олон нийтэд сурталчлах;

14.7.9.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, заавар, маягт, зөвлөмж батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

14.7.10.олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, тухайн газар, объектод саадгүй нэвтрэх, холбогдох мэдээ, баримт бичгийг гаргуулж танилцах, түүнийг хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, ил тод байдлын тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах; Тайлбар: Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 14.7.10-т заасан бүрэн эрхийг ажлын хэсэг болон төлөөлөгч томилж хэрэгжүүлж болно.

14.7.11.энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбосон олборлох үйлдвэрлэлийн нэгдсэн портал ажиллуулах.

20.1.Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т заасан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан олборлох үйлдвэрлэлийн салбар тус бүрээр гаргах ба тайлан хүлээн авсан жилийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэн олон нийтэд мэдээлж, Засгийн газарт хүргүүлнэ

21.5.Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн

<p>тайланд тусгагдсан зөрүүг хэрхэн шийдвэрлэж болох талаарх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.</p> <p>13.6.Холбогдох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь мэдээллийг тодорхой хугацаагаар нууцлах хүсэлт гаргаж болох бөгөөд тухайн хүсэлтийг Үндэсний зөвлөл шийдвэрлэнэ.</p>	
<p>15.1.Үндэсний зөвлөл нь дараах чиг үүрэг бүхий бие даасан Ажлын албатай байна:</p> <p>15.1.1.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг хүлээн авах;</p> <p>15.1.2.энэ хуульд заасан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг боловсруулах;</p> <p>15.1.3.мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;</p> <p>15.1.4.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;</p> <p>15.1.5.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>15.2.Үндэсний зөвлөл нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг баталж, үйл ажиллагааны төсвийн саналыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайдад хүргүүлнэ.</p> <p>15.3.Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилно.</p> <p>15.8.Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг Ажлын алба өөрийн цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байна.</p> <p>21.1.Ажлын алба нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгасан мэдээллийн зөрүүг тодруулах хүсэлтийг холбогдох тайлан гаргасан үүрэг бүхий этгээдэд хүргүүлж болно.</p> <p>21.3.Ажлын алба нь энэ хуулийн 21.2-т заасан мэдээлэл, тайлбарыг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн этгээд шаардлагатай тохиолдолд зөрүү үүсгэж байгаа мэдээлэлтэй танилцаж болно.</p> <p>21.4.Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгах бөгөөд энэ талаар тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.</p>	<p>12.8.Цахим хэлбэрээр эрх бүхий байгууллагад илгээсэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулах боломжгүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлнэ.</p> <p>12.9.Мэдээлэл нийлүүлэгч мэдээллийн санд оруулсан мэдээлэл, тайланг оруулснаас хойш 3 сарын дотор багтаан засаж залруулж болно.</p> <p>6.6.Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, шинэчлэх үүрэг бүхий этгээд баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэнэ.</p> <p>12.2.Энэ хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь буюу анхан шатны тайлан, мэдээллийг зөвшөөрөл эзэмшигч, түүнийг нэгтгэсэн мэдээллийг холбогдох төрийн байгууллага хариуцаж мэдээллийн санд оруулахаар тогтооно.</p> <p>12.3.Энэ хуульд заасан мэдээлэл, түүнийг хариуцах мэдээлэл нийлүүлэгчийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн санд бүртгэнэ.</p>

<p>13.1.Амьтан агнах, барих болон ойн баялаг, усны нөөц, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.</p>	<p>13.3.Мэдээллийн сан хариуцагч этгээд нь мэдээллийн сангийн бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сангийн хэвийн, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан хангаж ажиллах үүрэгтэй.</p>
<p>13.2.Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна. 14.6.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгоно.</p>	<p>13.3.Мэдээллийн сан хариуцагч этгээд нь мэдээллийн сангийн бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сангийн хэвийн, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан хангаж ажиллах үүрэгтэй.</p>
<p>17.1.Төрийн байгууллагын ил тод байдлын тайланг энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага гаргана. 17.2.Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гаргаж, мэдээллийн санд оруулна. 17.3.Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.</p> <p>14.10.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуульд заасан салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж, батлуулахаар Үндэсний зөвлөлд санал хүргүүлнэ. Тайлбар: Сум, дүүрэг нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахгүй бөгөөд холбогдох мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлд хүргүүлнэ. .</p> <p>25.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 25.1.1.зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх; 25.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх.</p>	<p>.</p>

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дах аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо дараах байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 2. Төрийн байгууллагын стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
УИХ	23.1.Улсын Их Хурлаас олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 23.1.1.Засгийн газраас хүргүүлсэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж Засгийн газарт чиглэл өгөх.	<ul style="list-style-type: none"> - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүр байнгын хороогоор хэлэлцэх, - Тайланд холбогдуулж зөвлөмж, санал, дүгнэлт боловсруулж, албажуулан хүргүүлэх.
ЗГ	24.1.Засгийн газар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.1.1.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 24.1.2.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг салбар тус бүрээр хэлэлцэн, шаардлагатай арга хэмжээний саналын хамт 8 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд хүргүүлэх;	<ul style="list-style-type: none"> - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг салбар тус бүрээр хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулах - Жил бүр Улсын Их Хуралд хүргүүлэх - Мэдээлэл нийлүүлэгчийг Үндэсний зөвлөлийн саналыг саналыг үндэслэн Засгийн газраас тогтооно.

	<p>24.1.3.энэ хуулийн 23.1.1-д заасан Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн биелэлтийг хангах арга хэмжээ авах.</p> <p>12.1.Энэ хуульд заасан мэдээллийг ил тод байлгах, мэдээллийн санд оруулах, тус мэдээллээр ил тод байдлын тайлан гаргах үүрэг бүхий этгээд /цаашид “мэдээлэл нийлүүлэгч” гэх/-ийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраас тогтооно.</p>	
<p>Үндэсний зөвлөл</p>	<p>14.7.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.7.1.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан салбар бүрээр хэлэлцэх, олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх;</p> <p>14.7.2.олборлох үйлдвэрлэлд үйл ажиллагаатай холбогдуулан төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигч, иргэн, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, хоорондын зохистой харилцаа, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг дэмжих;</p> <p>14.7.3.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг үндэслэн авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон зөвлөмж гаргах, зөвлөмжийг холбогдох этгээдэд хүргүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар шаардах, хариу, мэдээлэл авах;</p> <p>14.7.4.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;</p> <p>14.7.5.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;</p>	<ul style="list-style-type: none"> - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан салбар бүрээр хэлэлцэх - Ил тод байдлын тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах - Тайланг үндэслэн авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон зөвлөмж гаргах, холбогдох этгээдэд хүргүүлэх, - Тус тайланг олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх; - Хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбосон олборлох үйлдвэрлэлийн нэгдсэн портал ажиллуулах. - Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих; - Оролцогч этгээдүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг дэмжих; - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах; - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах; - Холбогдох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь

<p>14.7.6.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой санал боловсруулж, төрийн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;</p> <p>14.7.7.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, хяналт тавих, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах;</p> <p>14.7.8.энэ хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа тайлан гаргагч зөвшөөрөл эзэмшигч болон төр, иргэний нийгмийн байгууллагыг олон нийтэд сурталчлах;</p> <p>14.7.10.олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, тухайн газар, объектод саадгүй нэвтрэх, холбогдох мэдээ, баримт бичгийг гаргуулж танилцах, түүнийг хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, мэргэжилтэн оролцуулж дүгнэлт гаргуулах, мэдээлэл, ил тод байдлын тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах;</p> <p>Тайлбар: Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 14.7.10-т заасан бүрэн эрхийг ажлын хэсэг болон төлөөлөгч томилж хэрэгжүүлж болно.</p> <p>14.7.11.энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбосон олборлох үйлдвэрлэлийн нэгдсэн портал ажиллуулах.</p> <p>20.1.Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т заасан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан олборлох үйлдвэрлэлийн салбар тус бүрээр гаргах ба тайлан хүлээн авсан жилийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэн</p>	<p>мэдээллийг тодорхой хугацаагаар нууцлах хүсэлт гаргаж болох бөгөөд тухайн хүсэлтийг Үндэсний зөвлөл шийдвэрлэх;</p> <p>- Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилох:</p>
---	--

	<p>олон нийтэд мэдээлж, Засгийн газарт хүргүүлнэ</p> <p>21.5.Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгагдсан зөрүүг хэрхэн шийдвэрлэж болох талаарх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.</p> <p>13.6.Холбогдох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь мэдээллийг тодорхой хугацаагаар нууцлах хүсэлт гаргаж болох бөгөөд тухайн хүсэлтийг Үндэсний зөвлөл шийдвэрлэнэ.</p> <p>15.3.Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилно.</p>	
<p>Үндэсний зөвлөлийн Ажлын алба</p>	<p>15.1.Үндэсний зөвлөл нь дараах чиг үүрэг бүхий бие даасан Ажлын албатай байна:</p> <p>15.1.1.энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгчээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг хүлээн авах;</p> <p>15.1.2.энэ хуульд заасан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг боловсруулах;</p> <p>15.1.3.мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;</p> <p>15.1.4.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;</p> <p>15.1.5.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>15.2.Үндэсний зөвлөл нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг баталж, үйл ажиллагааны төсвийн саналыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайдад хүргүүлнэ.</p> <p>15.8.Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг Ажлын алба өөрийн цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой байдлаар</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл нийлүүлэгчээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг хүлээн авах; - Тайланд тусгасан мэдээллийн зөрүүг тодруулах; - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг боловсруулах; - Холбогдох сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх; - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах; - Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; - Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг цахимаар олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байх;

	<p>байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байна.</p> <p>21 дүгээр зүйл. Ил тод байдлын тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх</p> <p>21.1. Ажлын алба нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгасан мэдээллийн зөрүүг тодруулах хүсэлтийг холбогдох тайлан гаргасан үүрэг бүхий этгээдэд хүргүүлж болно.</p> <p>21.3. Ажлын алба нь энэ хуулийн 21.2-т заасан мэдээлэл, тайлбарыг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн этгээд шаардлагатай тохиолдолд зөрүү үүсгэж байгаа мэдээлэлтэй танилцаж болно.</p> <p>21.4. Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд тусгах бөгөөд энэ талаар тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.</p>	
<p>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>13.1. Амьтан агнах, барих болон ойн баялаг, усны нөөц, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.</p>	<p>- Амьтан агнах, барих болон ойн баялаг, усны нөөц, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг хариуцах.</p>
<p>Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>13.2. Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.</p> <p>14.6. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгоно.</p>	<p>- Геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах.</p> <p>- Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгох.</p>

<p>Мэдээллийн сан хариуцагч</p>	<p>13.3.Мэдээллийн сан хариуцагч этгээд нь мэдээллийн сангийн бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сангийн хэвийн, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан хангаж ажиллах үүрэгтэй.</p> <p>6.6.Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, шинэчлэх үүрэг бүхий этгээд баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэнэ.</p> <p>12.3.Энэ хуульд заасан мэдээлэл, түүнийг хариуцах мэдээлэл нийлүүлэгчийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн санд бүртгэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн сан хариуцагч этгээд нь мэдээллийн сангийн бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлэх. - Мэдээллийн сангийн хэвийн, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан хангаж ажиллах. - Хуульд заасан мэдээлэл, түүнийг хариуцах мэдээлэл нийлүүлэгчийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах.
<p>Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага</p>	<p>12.2.Энэ хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь буюу анхан шатны тайлан, мэдээллийг зөвшөөрөл эзэмшигч, түүнийг нэгтгэсэн мэдээллийг холбогдох төрийн байгууллага хариуцаж мэдээллийн санд оруулахаар тогтооно.</p> <p>17 дугаар зүйл.Төрийн байгууллагын ил тод байдлын тайлан</p> <p>17.1.Төрийн байгууллагын ил тод байдлын тайланг энэ хуульд заасан мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага гаргана.</p> <p>17.2.Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гаргаж, мэдээллийн санд оруулна.</p> <p>17.3.Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.</p>	<ul style="list-style-type: none"> - Хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь буюу анхан шатны тайлан, мэдээллийг мэдээллийн санд оруулах - Төрийн байгууллагын ил тод байдлын тайланг гаргах, мэдээллийн санд оруулах, хүргүүлэх. - Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны тайлангийн зөрүү тодруулах хүсэлтэд хариу өгөх.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг	14.10.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуульд заасан салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж, батлуулахаар Үндэсний зөвлөлд санал хүргүүлнэ. Тайлбар: Сум, дүүрэг нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахгүй бөгөөд холбогдох мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлд хүргүүлнэ.	- Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох хүсэлтийг Үндэсний зөвлөлд хүргүүлэх.
	25.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 25.1.1.зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх; 25.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх.	- Зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх; - Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх.

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хүснэгт 3. Төрийн байгууллагын гүйцэтгэх стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХ	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүр байнгын хороогоор хэлэлцэх	480 ¹	1	480

¹ 480 минут буюу ажлын 8 цаг.

	Тайланд холбогдуулж зөвлөмж, санал, дүгнэлт боловсруулж, албажуулан хүргүүлэх	480	1	480
ЗГ	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг салбар тус бүрээр хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулах	480 ²	5	2400
	Жил бүр Улсын Их Хуралд хүргүүлэх	640	1	640
	Мэдээлэл нийлүүлэгчийг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраас тогтоох	960	1	960
Үндэсний зөвлөл	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг энэ хуульд заасан салбар бүрээр хэлэлцэх	480	5	2400
	Ил тод байдлын тайлангийн үнэн зөв байдлыг нягтлах	480	5	2400
	Тайланг үндэслэн авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон зөвлөмж гаргах, холбогдох этгээдэд хүргүүлэх,	480	2 ³	960
	Тус тайланг олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх;	480	1	480
	Хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбосон олборлох үйлдвэрлэлийн	1440 ⁴	365	525600

² Хуулийн төслийн 6.1 дэх хэсэгт зааснаар олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн сан нь 5 төрөлтэй байна. Иймд төрөл бүрээр буюу салбар бүрээр гаргасан тайланг тус тусад нь хэлэлцэнэ гэж үзэв.

³ Хуулийн төслийн 13.1 дэх хэсэгт амьтан агнах, барих болон ойн баялаг, усны нөөц, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 13.2 дахь хэсэгт зааснаар эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар заасан.

⁴ 24 цагийн туршид хэвийн ажиллана гэж үзэв.

нэгдсэн портал ажиллуулах.			
Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих;	96000	1 ⁵	96000
Оролцогч этгээдүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг дэмжих;	96000	1	96000
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;	96000	1	96000
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;	96000	1	96000
Холбогдох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь мэдээллийг тодорхой хугацаагаар нууцлах хүсэлт гаргаж болох бөгөөд тухайн хүсэлтийг Үндэсний зөвлөл шийдвэрлэх;	96000	1	96000

⁵ Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралт аргачлалын 4.4.3.2-д зааснаар үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэдэн жилээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно. Иймд Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилт, мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл бүрэн нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж үзэв.

	Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилох;	480	1	480
Үндэсний зөвлөлийн Ажлын алба	Мэдээлэл нийлүүлэгчээс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг хүлээн авах;	60	5820 ⁶	349200
	Тайланд тусгасан мэдээллийн зөрүүг тодруулах;	60	582 ⁷	34920
	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланг боловсруулах;	2400	1	2400
	Холбогдох сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх;	2400	2	4800
	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын	2400	2	4800

⁶ Уг мэдээллийн санд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шууд, аймаг, нийслэлийн ИТХ нь Засаг даргын тамгын газраар дамжуулан, аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эрхэлсэн асуудлын хүрээнд холбогдох мэдээллийг нэгтгэж, **нийт 64 мэдээлэл нийлүүлэгч** төрийн байгууллага, холбогдох байгалийн нөөцийн ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **нийт 5756 гаруй мэдээлэл нийлүүлэгч хуулийн этгээд** буюу зөвшөөрөл эзэмшигч ил тод байдлын тайлан ирүүлнэ гэж тооцлоо. Амьтны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэргийг үндэслэвэл амьтан барих агнах үйл ажиллагаанд Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг нийслэл, сум, дүүргийн ИТХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тухайн нутаг дэвсгэрийн Байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага, бусад зорилгоор амьтан агнах, барих эрх авсан хуулийн этгээд нар оролцож байна.

- Ургамлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэргийг үндэслэвэл байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагаанд мөн адил Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг нийслэл, сум, дүүргийн ИТХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тухайн нутаг дэвсгэрийн Байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, аливаа зорилгоор ургамал ашиглах эрх авсан хуулийн этгээд голлон оролцож байна.
- Ойн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар ойн баялаг ашиглах харилцаанд Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, нутаг дэвсгэрийн Засаг дарга, сум дундын болон сум дүүргийн ойн анги, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага, ойн сан болон түүний тодорхой хэсгийг эзэмшиж, ашиглах эрхтэй, ойг ашиглах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, аж ахуй нэгж зэрэг байгууллага голлон оролцдог.
- Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах харилцаанд Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга, сум дүүргийн Байгаль хамгаалагч, ус ашиглах, цооног өрөмдөх, худаг гаргах, суваг хоолой татах, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд голлон оролцож байна.
- Ашигт малтмалын тухай хуулийг үндэслэл эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Төрийн захиргааны төв байгууллага, Төрийн захиргааны байгууллага, нутаг дэвсгэрийн ИТХ, Засаг дарга, болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд голчлон оролцдог.

⁷ Ирүүлсэн нийт тайлангийн 10 хувьд нь зөрүү гарна гэж үзлээ.

	уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах;			
	Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	96000	1	96000
	Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн санг цахимаар олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлж, тогтмол шинэчилж байх;	480	365	175200
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Амьтан агнах, барих болон ойн баялаг, усны нөөц, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг хариуцах.	96000	1	96000
Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцах.	96000	1	96000
	Үндэсний зөвлөлийн даргыг Засгийн газарт санал болгох.	480	1	480
Мэдээллийн сан хариуцагч	Мэдээллийн сан хариуцагч этгээд нь мэдээллийн сангийн бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлэх.	96000	1	96000
	Мэдээллийн сангийн хэвийн, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцан хангаж ажиллах.	96000	1	96000
	Хуульд заасан мэдээлэл, түүнийг хариуцах мэдээлэл нийлүүлэгчийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах.	60	5746 ⁸	344760

⁸ Энэхүү судалгааны 2 дахь хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага	Хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь буюу анхан шатны тайлан, мэдээллийг мэдээллийн санд оруулах	96000	1	96000
	Төрийн байгууллагын ил тод байдлын тайланг гаргах, мэдээллийн санд оруулах, хүргүүлэх.	2400	1	2400
	Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны тайлангийн зөрүү тодруулах хүсэлтэд хариу өгөх.	480	1 ⁹	24000
Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг	Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох хүсэлтийг Үндэсний зөвлөлд хүргүүлэх	2400	1	2400
	Зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх;	2400	1 ¹⁰	2400
	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх.	960	1	960
Нийт				2542000

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

⁹ Тухай бүр тодруулга өгөх тул аргачлалд зааснаар тохиолдлын тоог хамгийн багадаа 1 гэж үзэв.

¹⁰ Тохиолдлын тоог тодорхойлох боломжгүй бол 1 гэж үзнэ.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
УИХ	960	96000	0.01
ЗГ	4000	96000	0.04
Үндэсний зөвлөл	1012320	96000	10.5
Үндэсний зөвлөлийн Ажлын алба	667320	96000	6.95
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	96000	96000	1
Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	96480	96000	1.005
Мэдээллийн сан хариуцагч	536760	96000	5.6
Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага	122400	96000	1.275
Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	5760	96000	0.06

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн хэрэгжүүлэхэд УИХ, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-д төдийлөн ачаалал үүсэхгүй. Харин Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхэд нийт 17 албан хаагч (Үндэсний зөвлөлийн гишүүн үүнд хамаарна), Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хамгийн багадаа 1 албан хаагч, Мэдээллийн сан хариуцагч төрийн байгууллагад 6 албан хаагч, мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага бүрд 1 албан хаагч шаардлагатай гэж үзэв.

2.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээг үндэслэвэл Төрийн захиргааны байгууллагын нэг албан хаагчийн сарын дундаж цалин нь

1,548,000 төгрөг байна.¹¹ Эндээс жилийн дундаж цалинг нь 18,576,000 төгрөг, түүнд оногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээг 2,322,000 төгрөг, нийт **20,898,000** төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Үндэсний зөвлөл, түүний ажлын алба	17	20,898,000	355,266,000.00
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1	20,898,000	20,898,000.00
Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1	20,898,000	20,898,000.00
Мэдээллийн сан хариуцагч	5	20,898,000	104,490,000.00
Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага	1	20,898,000	20,898,000.00

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд

¹¹ Албан тушаалын зэрэглэлээр тогтоосон цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

T3-1	2,218,000
T3-2	1,974,000
T3-3	1,862,000
T3-4	1,757,000
T3-5	1,597,000
T3-6	1,452,000
T3-7	1,320,000
T3-8	1,200,000
T3-9	1,100,000
T3-10	1,000,000

оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1,411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,395,434

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 7. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал

Нэгж	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
Үндэсний зөвлөл, түүний ажлын алба	355,266,000.00	91,722,378	446,988,378.00
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	20,898,000.00	5,395,434	26,293,434.00
Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	20,898,000.00	5,395,434	26,293,434.00
Мэдээллийн сан хариуцагч ¹²	104,490,000.00	26977170	131,467,170.00
Нийт			631,042,416.00
Мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага	20,898,000.00	5,395,434	26,293,434.00
Нийт			26,293,434.00

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Үндэсний зөвлөл, түүний ажлын алба, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 631,042,416 төгрөгийн зардал гарахаар байгаа бол мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага бүрт 26,293,434.00 төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

¹² Хуулийн төслийн 13 дугаар зүйлд зааснаар мэдээлэл хариуцагч байгууллага нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн ил тод сан нь 5 төрөлтэй байхаар тусгасан. Эрдэс баялгийн олборлолт, байгалийн амьтан агнах барих, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах, ойн баялаг болон байгалийн ургамлын нөөц ашиглах чиглэлд 60 гаруй төрийн байгууллага¹³, 5700 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч¹⁴ үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Энэхүү зардлын тооцооны хүрээнд үргэлжилсэн шинжтэй чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж, тайлан хүлээж авах, тайлангийн зөрүүг шалгах, мэдээлэл нийлүүлэгчийг мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах зэрэг чиг үүргийн тохиолдлын тоог нийт тусгай эзэмшигчийн тоогоор буюу 5756 гэж үзсэн.

Эндээс үзвэл хуулийн үйлчлэх хүрээг хумьж гагцхүү эрдэс баялгийн олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлан гаргах, мэдээлэл нийлүүлэх үүрэг хүлээлгэснээр тохиолдлын тоог бууруулж, зардлыг багасгана. Гэвч бусад төрлийн байгалийн баялаг (амьтан, ургамал, ойн баялаг, усны нөөц)-ийн нөөцийг хэрхэн ашиглаж, хэрхэн нөхөн сэргээж буй талаарх мэдээлэл иргэдэд хүртээмжгүй байх бөгөөд энэ төрлийн байгалийн баялгийг ашиглаж буй этгээдийг хариуцлагажуулах нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцэх тул тохиолдлын тоог дээрх байдлаар бууруулах нь оновчгүй гэж үзэв.

2.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төслийн 7, 8, 9, 10, 11 дүгээр зүйлд ил тод мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага, хуулийн этгээдээс нийлүүлсэн байх мэдээллийг дэлгэрэнгүй тусгасан. Гэсэн хэдий ч хуулийн төсөлд дээрх мэдээллийг хүргүүлэх давтамжийг тодорхой заагаагүй тул давтамжийн тоог 1 гэж үзсэн. Иймд мэдээлэл хүргүүлэх давтамжийг бууруулах боломжгүй гэж үзлээ.

Мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх тул давтамжийг багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй. Гэвч цахимаар эсхүл мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх олгох байдлаар эсхүл автоматаар мэдээллийг хүргүүлэх боломжтой байх нь цаг хугацаа, холбогдох зардлыг хэмнэнэ. Жишээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан төлбөр, хураамжийг төлсөн тохиолдолд татварын албанаас төлсөн хураамжийн мэдээллийг уг санд дахин оруулах нь зардал их үүсгэх тул холбогдох санг татварын систем(үүд)-тэй холбох нь зүйтэй.

2.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

¹³ Энэхүү судалгааны тайлангийн 7 дахь эшлэлээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

¹⁴ Энэхүү судалгааны тайлангийн “Хүснэгт 14. Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тохиолдлын тоо”-г дэлгэрэнгүйг үзнэ үү.

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй.

Гэвч зарим төрлийн мэдээлэл нь төрийн бусад байгууллагын мэдээллийн санд төвлөрсөн бол тус сан рүү дамжин үзэх холбоосыг оруулах байдлаар давхцал үүсгэхгүй байх шийдлийг ашиглах нь мэдээллийн үнэн зөв бус байдал, зөрүүтэй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Цаашлаад мэдээллийн үнэн зөв бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс аль төрлийн мэдээллийг хэн хариуцах асуудлыг нухацтай шийдвэрлэх шаардлагатай байгаа бөгөөд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хэт хүндрэл учруулахаас зайлсхийх нь зүйтэй. Тухайлбал, төслийн 7.1.2а хэсэгт тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийн огноо, бүртгэсэн огноо зэрэг мэдээллийг мэдээллийн санд оруулсан байхыг шаарджээ. Гэвч энэ төрлийн мэдээллийг нэгэнт хүсэлт гаргасан эсхүл түүнийг бүртгэсний дараа системд оруулах зорилгоор эргэн цуглуулах нь оновчгүй тул анх хүсэлт гаргахдаа системээр дамжуулан хүсэлт гаргах эсхүл цаашлаад ирүүлсэн хүсэлтийг бүртгэх зэрэг үйлдлийг хийх боломжтой байхаар системийг хөгжүүлэх нь олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг ил тод байдлыг хангахаас гадна тухайн процессыг хялбаршуулахад чухал ач холбогдолтой байж болохоор байна гэж үзлээ.

2.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төсөлд “Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, шинэчлэх үүрэг бүхий этгээд баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэнэ” гэжээ.

Гэвч ил тод байдлын тайланг цахимаар хүргүүлэх эсэх асуудлыг нягталж, цахимаар хүргүүлэх боломжийг системд бүрдүүлэх нь чухал.

2.5.5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог хамгийн багаар тогтоосон байна. Гэвч мэдээлэл нийлүүлэгч нь тухайн төрлийн мэдээллийг зохих дээд шатны байгууллагад хүргүүлдэг бол мэдээллийн сангаар дамжуулан дээд шатны байгууллагадаа хүргүүлэх боломжийг бүрдүүлж болох юм. Ингэснээр мэдээлэл нийлүүлэгч нэг мэдээллийг 2 өөр этгээдэд хүргүүлэхээр давхар зардал, цаг хугацаа зарцуулахгүй.

III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;

Тус хуулийн төсөлд тусгагдсанаар дараах төрлийн мэдээллүүдийг хуулийн этгээдүүд мэдээллийн санд оруулахаар зохицуулжээ

Хүснэгт 8. Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээллийн жагсаалт /сангийн төрлөөр/

Мэдээллийн сангийн төрөл	Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээлэл
Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	<p>7.1.3.дараах гэрээ, хэлэлцээр, түүний нэмэлт, өөрчлөлт болон хэрэгжилтийн мэдээлэл:</p> <p>7.1.3.а.бүтээгдэхүүн хуваах гэрээ;</p> <p>7.1.3.б.орд ашиглах гэрээ;</p> <p>7.1.3.в.хөрөнгө оруулалтын гэрээ, түүнтэй адилтгах гэрээ</p> <p>7.1.3.г.зөвшөөрөл олгогчоос зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;</p> <p>7.1.3.д.нутгийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;</p> <p>7.1.3.е.зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан газар ашиглах гэрээ;</p> <p>7.1.3.ё.усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ;</p> <p>7.1.3.ж.зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан ус ашиглах гэрээ;</p> <p>7.1.3.з.бичил уурхай эрхлэгчтэй байгуулсан гэрээ;</p> <p>7.1.3.и.нөхөн сэргээлтийн гэрээ;</p> <p>7.1.4.зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:</p> <p>7.1.4.б.Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хянагдсан, ашигт малтмал ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж болон зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, холбогдох гүйцэтгэлийн тайлангийн нууцад хамааруулснаас бусад мэдээлэл;</p> <p>7.1.4.в.Байгаль орчны албаны зөвшөөрөл;</p> <p>7.1.4.г.Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэр;</p> <p>7.1.4.д.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн судалгааны ажлын тайлан, дүгнэлт;</p> <p>7.1.4.ё.цацраг идэвхт ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үйл</p>

ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандартын шаардлага хангасан талаарх төрийн захиргааны байгууллагын үнэлгээ, цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, цацрагийн түвшний 7 хоног тутмын мэдээлэл;

7.1.5.эрдэс баялаг хайгуулын мэдээлэл:

7.1.5.а.эрх бүхий байгууллагаар хянуулсан хайгуулын ажлын төлөвлөгөө, холбогдох гүйцэтгэлийн тайлангийн нууцад хамааруулснаас бусад мэдээлэл;

7.1.6.эрдэс баялаг олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын мэдээлэл:

7.1.6.а.зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн олборлосон, баяжуулсан, боловсруулсан эрдэс баялаг, баяжмал, бүтээгдэхүүний төрөл, төрөл тус бүрийн хэмжээ;

7.1.6.б.тухайн жилд Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан үнэт металл, тэдгээрийн сорьц, чанар, хэмжээ, худалдан авахад баримталсан олон улсын зах зээлийн үнэ, урамшуулалтай үнэ, төлбөр төлөлтийн мэдээлэл;

7.1.6.в.зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд борлуулсан эрдэс баялгийн тоо хэмжээ, төрөл, борлуулалтын үнэ, тухайн үеийн олон улсын зах зээлийн үнийн ханш, борлуулалтын орлого, худалдан авагч этгээдийн нэр/иргэн бол эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа хаяг/;

7.1.6.г.зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд төлбөр тооцоонд шилжүүлэн өгсөн эрдэс баялгийн төрөл, хэмжээ, түүний төлбөр тооцооны үнэлгээ буюу борлуулсан үнэ, эрдэс баялгийн тухайн үеийн олон улсын зах зээлийн үнийн ханш, борлуулалтын орлого, төлбөр тооцоонд шилжүүлэн авсан этгээдийн нэр/иргэн бол эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа хаяг;

7.1.6.д.тухайн жилд борлуулсан, экспортолсон эрдэс баялгийн төрөл, төрөл тус бүрийн хэмжээ, орлого, борлуулалтын үнэ, хүлээн авагч улс;

7.1.6.е.эрдэс баялгийн тээвэрлэлт гүйцэтгэгч этгээдийн жагсаалт, тэдгээрийн тухайн жилд олсон тээвэрлэлтийн орлого, тээвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл, тэдгээрийн тоо хэмжээ, тээвэрлэлтийн үнэ тариф, бусад төлбөр, тээвэрлэлт гүйцэтгэх арга, тээврийн хэрэгслийн төрөл, замын төрөл, төмөр зам,

улсын болон орон нутгийн чанартай автозам ашигласны төлбөр, тээвэрлүүлэгч этгээдийн нэр/иргэн бол эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр/, тээвэрлэлт гүйцэтгүүлэх хүсэлтийн бүртгэл, хүсэлтийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут, хүсэлтийн дагуу тээвэрлэлт гүйцэтгэсэн эсэх талаарх мэдээлэл;

7.1.6.ё.зөвшөөрөл эзэмшигчийн өөрөө тээвэрлэсэн болон бусдаар тээвэрлүүлсэн эрдэс баялгийн төрөл, хэмжээ, тээвэрлэлт гүйцэтгүүлсэн арга, тээврийн хэрэгсэл, замын төрөл, зардал, тээвэрлүүлсэн үнэ тариф, бусад төлбөр, тээвэрлэгч этгээдийн нэр/иргэн бол эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр/;

7.1.9.зөвшөөрөл эзэмшигчээс нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн зарцуулалт:

7.1.9.а.бусдад өгсөн хандив, дэмжлэг, тусламж, урамшууллын хэмжээ, хэлбэр, зориулалт, гэрээ;

7.1.9.б.нийгмийн хариуцлагын хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн нийт дүн;

7.1.9.в.нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжүүлэхэд гарсан зардлын хэмжээ;

7.1.9.г.Газрын тосны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасны дагуу төлсөн хохирол нөхөн төлөлт, холбогдох бусад зардлын мэдээлэл;

7.1.10.уурхайн хаалт, байгаль орчин нөхөн сэргээлтийн мэдээлэл:

7.1.10.б.зөвшөөрөл эзэмшигчээс уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгосон арга хэмжээний тайлан;

7.1.10.в.зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарсан зардлын дүн, хэрэгжилтийн тайлан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээний зардлын дүн, тайлан;

7.1.10.г.зөвшөөрөл эзэмшигчээс уурхайн эдэлбэр байсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлэх арга хэмжээний тайлан;

7.1.10.е.эвдэрсэн, нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, нөхөн сэргээлтийн ангилал, байршил, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн этгээд, түүний зөвшөөрөл, төсөл тус бүрээр;

7.1.11.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл:

7.1.11.а.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч хүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр,

харьяалал, төрсөн огноо, улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх мэдээлэл.

7.1.12.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой мэдээлэл:

7.1.12.а.урт богино хугацааны бизнес төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшин, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөгөө, шийдвэр, түүнтэй холбоотой техник-эдийн засгийн үнэлгээний нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, тооцоо, судалгаа, санхүүжилт, ногдол ашгийн бодлого, хуваарилалт; 7.1.12.б.бусдаас авсан, бусдад өгсөн зээл, зээлийн гэрээ, зээлийн баталгаа, батлан даалтын мэдээлэл, үнэт цаас гаргах шийдвэр, гаргасан үнэт цаасны төрөл, хэмжээ, нөхцөл, эргэн төлөгдөх хуваарь, бусад дансны бус өр төлбөр, төлбөрийн үүргийн дэлгэрэнгүй мэдээлэл;

7.1.12.в.санхүү, техникийн нөөц, хүний нөөцийн төлөвлөгөө, төсвийн зарцуулалтын тайлан;

7.1.12.г.санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж, жил, улирал тутмын санхүү байдлын тайлан, орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тэдгээрийн тодруулгыг жил, улирлаар;

7.1.12.д.олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, худалдан авалттай холбогдох гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээлэл;

7.1.12.е.улсын төсвөөс авсан татаас, хөнгөлөлт, мөнгөн болон мөнгөн бус шилжүүлэг, төсвийн шинжтэй зарцуулалт, тэдгээртэй холбоотой шийдвэр;

7.1.12.ё.төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх шийдвэр, гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээлэл, төрийн өмчийг захиран зарцуулах талаар олгосон эрхийн мэдээлэл;

7.1.12.ж.Засгийн газар, орон нутагт ногдох хувьцааны ногдол ашиг, ашигт газрын тосны хэмжээ, төлбөр, бусад орлого болон материаллаг үр өгөөж;

7.1.14.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн талаарх мэдээлэл:

7.1.14.а.тухайн зөвшөөрөлд хамаарах эрдэс баялгийн олборлох үйлдвэрлэлийн мэдээлэл,

	<p>эдийн засагт үзүүлэх үр өгөөж, таамаглал, тооцоолол;</p> <p>7.1.14.б.газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;</p> <p>7.1.14.в.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн нийт ажилтны тоонд гадаад ажилтны эзлэх хувь, ажиллах байршил, ажлын байрны нэр, холбогдох зөвшөөрөл, Монгол Улсын иргэдийн хүйс, боловсрол, ажиллаж байгаа хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны нэр;</p> <p>7.1.14.г.зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын мэдээлэл;</p> <p>7.1.15.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл:</p> <p>7.1.15.а.зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий байгууллагаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүний биелэлтийн тайлан;</p> <p>7.1.15.е.байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, түүний тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл тус бүрээр;</p>
<p>Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагаа</p>	<p>8 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн сан</p> <p>8.1.3.ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, гэрээний хэрэгжилт;</p> <p>8.1.4.ус бохирдуулсны төлбөр төлөлтийн мэдээлэл, төлөгч тус бүрээр;</p> <p>8.1.12.ус ашиглагчийн зөвшөөрөл, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, эрхийн бичиг, гэрээ;</p> <p>8.1.14.ус ашиглагчийн хэрэгжүүлэх төслийн үргэлжлэх хугацаа, нэг жилийн усны хэрэгцээ;</p> <p>8.1.15.ус ашиглагчийн ашигласан усны хэмжээ;</p> <p>8.1.16.усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, төлөлтийн байдал.</p>
<p>Ойн баялаг ашиглах үйл ажиллагаа</p>	<p>9 дүгээр зүйл.Ойн баялаг ашиглах үйл ажиллагааны мэдээллийн сан</p> <p>9.1.3.ойн сан болон түүний тодорхой хэсгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн жагсаалт, байгуулсан гэрээ, ойн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан;</p> <p>9.1.11.бэлтгэсэн мод, модон материалд олгосон гарал үүслийн гэрчилгээ;</p>

	<p>9.1.12.ойн нөхөрлөлийн ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн жилийн тайлан;</p> <p>9.1.13.ойн нөхөрлөлийн бэлтгэсэн мод, ашигласан ойн дагалт баялгийн төрөл, хэмжээ, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулсны орлого;</p> <p>9.1.14.ойг ашиглах чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах болон ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл;</p> <p>9.1.15.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигчийн ашигласан мод, ойн дагалт баялгийн төрөл, хэмжээ;</p> <p>9.1.16.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч сум, дүүргийн төсөвт төлөх татварын хэмжээ, төлөлтийн мэдээлэл;</p> <p>9.1.19.ойн сан бүхий газарт ургадаг хушны самар, зэрлэг жимс, жимсгэнэ, мөөг, эмийн ашигт ургамлыг хамгаалах бүсүүдийг нутгийн иргэн, ойн нөхөрлөл, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлсэн бол тус гэрээ;</p>
Амьтан агнах, барих үйл ажиллагаа	<p>10 дугаар зүйл.Амьтан барих, агнах үйл ажиллагааны мэдээллийн сан</p> <p>10.1.20.иргэн, хуулийн этгээд гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа агнуурын бүс нутагтаа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж хийлгэсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, зардлын дүн;</p>
Байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагаа	-

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, иргэн, хуулийн этгээдийн зардалд нөлөөлөх зүйл заалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно.

Хүснэгт 9. Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Зөвшөөрөл эзэмшигч хуулийн	12.2.Энэ хуульд заасан мэдээллийн өөрт хамаарах суурь	-Хариуцагчийн мэдэгдсэнээр мэдээллийн санд бүртгүүлэх

<p>этгээд¹⁵</p>	<p>буюу анхан шатны тайлан, мэдээллийг зөвшөөрөл эзэмшигч, түүнийг нэгтгэсэн мэдээллийг холбогдох төрийн байгууллага хариуцаж мэдээллийн санд оруулахаар тогтооно. 12.4.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийн сан хариуцагчаас мэдэгдсэнээр заасан хугацаанд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах үүрэг хүлээнэ.</p>	
	<p>12.6.1.өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг ил тод байлгах, энэ хуульд заасан журам, шаардлага, хугацаа, маягтын дагуу мэдээллийн санд бүрэн, үнэн зөв оруулах, эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх, шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх</p>	<p>-Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг мэдээллийн санд оруулах - Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх - Шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх</p>
	<p>12.6.2.өөрийн хариуцах мэдээллийг өөрийн цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх.</p>	<p>- Өөрийн хариуцах мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх</p>
	<p>12.6.5.Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсан тодруулгын хариуг ажлын 10 өдөрт багтаан үнэн зөв гаргаж хүргүүлэх, шаардлагатай мэдээллийг харьяа байгууллага, албан тушаалтан, хамаарал бүхий нэгж, салбар, толгой, охин компаниар гаргуулж хүргүүлэх</p>	<p>- Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсаны дагуу тодруулга хүргүүлэх</p>
	<p>12.6.6.мэдээллийн санд оруулсан мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах</p>	<p>- Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах</p>
	<p>12.6.7.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх</p>	<p>- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх</p>
	<p>12.6.8.мэдээллийн санд мэдээллээ оруулах эрх бүхий албан тушаалтан нь бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх</p>	<p>- Мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх</p>

¹⁵ Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл авсан Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-т заасан этгээд

	<p>12.8.Цахим хэлбэрээр эрх бүхий байгууллагад илгээсэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулах боломжгүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлнэ.</p> <p>18 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын тайлан</p> <p>18.1.Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан цахимаар Үндэсний зөвлөлийн ажлын албанд ил тод байдлын тайлан гаргагчаар бүртгүүлж, тус тайланг баталгаажуулах эрх бүхий этгээдийн талаар мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>18.2.Энэ хуулийн 18.1-д заасан ил тод байдлын тайлан гаргагчаар бүртгүүлэх журам, ил тод байдлын тайлан баталгаажуулах эрх бүхий этгээдийн талаарх мэдэгдлийн маягтыг Үндэсний зөвлөл батална.</p> <p>18.3.Зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн ил тод байдлын тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргаж, мэдээллийн санд оруулах үүрэгтэй.</p> <p>18.4.Зөвшөөрөл эзэмшигч нь ил тод байдлын тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланд үндэслэн гаргана.</p>	<p>- Ил тод байдлын тайланг цахим гарын үсэггүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлэх</p> <p>- Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах</p>
Иргэний нийгмийн байгууллага	<p>19 дүгээр зүйл.Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлан</p> <p>19.1.Зөвшөөрөл эзэмшигчээс хандив, тусламж, дэмжлэг, урамшуулал зэрэг болон бусад аливаа хэлбэрээр санхүүжилт авсан иргэний нийгмийн байгууллага энэ хуулийн 16.1.3-т заасан ил тод байдлын тайланг жилээр гаргаж дараа оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор холбогдох мэдээллийн санд цахимаар оруулна.</p> <p>19.2.Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайланд дор дурдсан мэдээллийг тусгана:</p>	<p>- Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах</p>

	<p>19.2.1.үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын дэлгэрэнгүй мэдээлэл; 19.2.2.санхүүжилт, түүний зориулалт, зарцуулалтын мэдээлэл; 19.2.3.үйл ажиллагааны чиглэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, олборлолтын мэдээ, засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл; 19.2.4.энэ хуульд заасан мэдээллийн сангийн мэдээлэл нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, хэлцлийн мэдээлэл.</p>	
	<p>20.4.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайланд өгсөн иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг тухайн тайлан гаргагч этгээд, эсхүл дүгнэлт гаргасан иргэний нийгмийн байгууллагаас Үндэсний зөвлөлд хүргүүлж, танилцуулна.</p>	<p>- Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг хүргүүлэх</p>

3.2 Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Иргэн, хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрд зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Иргэн, хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Өмнөх хэсэгт хуулийн төсөлд тусгагдсан үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлсон. Иймд энэхүү хэсэгт тус хэсэгт тухайн үйлдэлд зарцуулагдах хугацаа, ажлын хөлсийг тодорхойлж гарч болох зардлыг тооцно.

3.2.1. Хугацааг тооцох

Хугацааг тодорхойлохдоо өөрсдийн тогтоосон стандарт үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг минутаар тооцоолж гаргана. Тухайн судалгаанд стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг тооцохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг

хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага¹⁶-д заасан жишиг хугацааг баримталлаа.

Хүснэгт 10. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

Чиг үүрэг гүйцэтгэгч	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (минутаар)
Зөвшөөрөл эзэмшигч	Хариуцагчийн мэдэгдсэнээр мэдээллийн санд бүртгүүлэх	40
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг мэдээллийн санд оруулах	10
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх	10
	Шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх	90
	Өөрийн хариуцах мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх	10
	Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсаны дагуу тодруулга хүргүүлэх	90
	Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах	120
	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх	120
	Мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх	70
	Ил тод байдлын тайланг цахим гарын үсэггүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлэх	10
	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	130
	Иргэний нийгмийн байгууллага	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах
Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг хүргүүлэх		130

3.2.2. Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг,

¹⁶ Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы хамтын ажиллагааны байгууллага (GIZ), Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага, 243-244 дэх тал.

мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Тус судалгааны хувьд хамгийн сүүлийн үеийн үзүүлэлтээр ажиллагчдын сарын дундаж цалин хөлсийг 2,009,300 төгрөг байхаар тооцож¹⁷, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

2,009,300 / 176 цаг = 11,416 төгрөг /цагт/

2,009,300 / 10560 минут = 190 төгрөг /мин/

Хүснэгт 11. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны зардал

Чиг үүрэг гүйцэтгэгч	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (минутаар)	Ажлын хөлс	Зардал
Зөвшөөрөл эзэмшигч	Хариуцагчийн мэдэгдсэнээр мэдээллийн санд бүртгүүлэх	40	190	7,600
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг мэдээллийн санд оруулах	10	190	1,900
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх	10	190	1,900
	Шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх	90	190	17,100
	Өөрийн хариуцах мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх	10	190	1,900
	Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсаны дагуу тодруулга хүргүүлэх	90	190	17,100
	Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах	120	190	22,800
	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх	120	190	22,800

¹⁷ Аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, <https://mce.mn/wp-content/uploads/2023/02/2022-%D0%BE%D0%BD%D1%8B-%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf>

	Мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх	70	190	13,300
	Ил тод байдлын тайланг цахим гарын үсэггүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлэх	10	190	1,900
	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	130	190	13,300
Иргэний нийгмийн байгууллага	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	130	190	13,300
	Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг хүргүүлэх	130	190	13,300
Нийт				148,200

3.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэдэн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Дээрх чиг үүргийн **тохиолдлын тоог** тогтоох боломжтой гэж үзэж, энэхүү зардлын тооцооны тайлангийн 1 дэх хэсэгт заасан статистикийг ашиглан тогтоолоо.

Тохиолдлын тоо:

Тохиолдлын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгаагаар илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрлийн тоогоор тохиолдлын тоог гаргана. Мэдээлэл хүргүүлэх үүргийн тухайд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоогоор илэрхийлж гаргана.

Хүснэгт 12. Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тохиолдлын тоо

№	Тохиолдол	Тохиолдлын тоо
1.	Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	3,077 ¹⁸
2.	Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	320 ¹⁹
3.	Ойн баялаг ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	1,871 ²⁰

¹⁸ Эрдэс баялаг олборлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, <https://ereporting.eitimongolia.mn/portalMap>

¹⁹ Ус цуглуулах, ариутгах, ус хангамжийн тусгай эрхтэй хуулийн этгээд, <https://www.opendatalab.mn/legalentity/3600/companies>

²⁰ Мод тарих болон ойн аж ахуй бусад үйл ажиллагааны тусгай эрхтэй хуулийн этгээд, <https://www.opendatalab.mn/legalentity/0210/companies>

Мод бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, <https://www.opendatalab.mn/legalentity/0220/companies>

Ойн дагалт нөөцийг түүх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд,

4.	Амьтан агнах, барих үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	79 ²¹
5.	Байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд	409 ²²
Нийт		5,756

Мөн түүнчлэн үйл ажиллагаагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудыг дараах байдлаар авч үзсэн.

Хүснэгт 13. Иргэний нийгмийн байгууллагын тохиолдлын тоо

№	Тохиолдол	Тохиолдлын тоо
1.	Иргэнийн нийгмийн байгууллага	17,634 ²³

Давтамжийн тоо:

Давтамж нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуй нэгж, байгууллага нэг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг харуулсан тоо юм. Тооцооны нэгж нь нэг жил байна. Энэхүү хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд мэдээллийг хүргүүлж байх хугацааг заагаагүй ба тухай бүр гаргаж байхаар зохицуулсан байна. Тиймээс давтамжийг 1 гэж авна.

Хүснэгт 14. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагааны тоон үзүүлэлт

Чиг үүрэг гүйцэтгэгч	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Зөвшөөрөл эзэмшигч	Хариуцагчийн мэдэгдсэнээр мэдээллийн санд бүртгүүлэх	5,756	1	5,756
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг мэдээллийн санд оруулах	5,756	1	5,756
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх	5,756	1	5,756
	Шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх	5,756	1	5,756
	Өөрийн хариуцах мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх	5,756	1	5,756

<https://www.opendatalab.mn/legalentity/0230/companies>

Ойн аж ахуйн туслах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд,

<https://www.opendatalab.mn/legalentity/0240/companies>

²¹ Амьтан агнах, барих үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд,

<https://www.opendatalab.mn/legalentity/0170/companies>

²² Байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд,

https://unece.org/DAM/env/epr/epr_studies/ECE_CEP_182_MN_small.pdf

²³ Konrad Adenauer stiftung, National University of Mongolia Department of Political Science, "Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа," Уб 2020,

<https://www.kas.de/documents/268650/268699/МОНГОЛ+ДАХЬ+АРДЧИЛАЛ%2С+ИРГЭНИЙ+НИЙГМИЙН+ӨНӨӨГИЙН+БАЙДЛЫН+НИЙГЭМ-УЛС+ТӨРИЙН+СУДАЛГАА+2020.pdf/a0d0d2e7-bba3-b47a-94f1-e004040f7f25?version=1.1&t=1591252250109>

	Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсаны дагуу тодруулга хүргүүлэх	5,756	1	5,756
	Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах	5,756	1	5,756
	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх	5,756	1	5,756
	Мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх	5,756	1	5,756
	Ил тод байдлын тайланг цахим гарын үсэггүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлэх	5,756	1	5,756
	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	5,756	1	5,756
Иргэний нийгмийн байгууллага	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	17,634	1	17,634
	Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг хүргүүлэх	17,634	1	17,634

3.4. Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 15. Хуулийн этгээдэд үүсэх нийт зардал

Чиг үүрэг гүйцэтгэгч	Стандарт үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт	Нэг бүрийн зардал	Нийт зардал
Зөвшөөрөл эзэмшигч	Хариуцагчийн мэдэгдсэнээр мэдээллийн санд бүртгүүлэх	5,756	7,600	43,745,600
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг мэдээллийн санд оруулах	5,756	1,900	10,936,400
	Өөрийн хариуцах мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланг эрх бүхий байгууллагад цахим гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх	5,756	1,900	10,936,400
	Шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөх	5,756	17,100	98,427,600
	Өөрийн хариуцах мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээлэх, тогтмол шинэчлэх	5,756	1,900	10,936,400

	Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсаны дагуу тодруулга хүргүүлэх	5,756	17,100	98,427,600
	Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах	5,756	22,800	131,236,800
	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх	5,756	22,800	131,236,800
	Мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх	5,756	13,300	76,554,800
	Ил тод байдлын тайланг цахим гарын үсэггүй тохиолдолд цаасан хэлбэрээр хүргүүлэх	5,756	1,900	10,936,400
	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	5,756	13,300	76,554,800
Нийт				699,929,600
Иргэний нийгмийн байгууллага	Ил тод байдлын тайланг боловсруулж, мэдээллийн санд оруулах	17,634	13,300	234,532,200
	Үндэсний зөвлөлд иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг хүргүүлэх	17,634	13,300	234,532,200
Нийт				469,064,400
Нийт зардал				1,168,994,000

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд дунджаар Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд **699,929,600** төгрөгийн зардал, Иргэний нийгмийн байгууллагад **469,064,400** төгрөгийн зардал тус тус гарах төлөвтэй байна. Нийт зардал **1,168,994,000** төгрөг гарахаар байна

3.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

3.5.1. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуульд тусгагдсан зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоог 5,756, иргэний нийгмийн 17,634 байхаар тус судалгаанд тооцсон. Энэхүү үзүүлэлтийг нийт хуулийн этгээдийн тоонд үндэслэсэн тул мэдээллийн санд мэдээлэл оруулах, ил тод байдлын тайлан гаргах, тодруулга гаргах зэрэг үйлдлүүдийг хийх хуулийн этгээдийн тоо багасна.

3.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүргийн давтамжийг жилд 1 байхаар тусгасан нь бага үзүүлэлт юм. Гэхдээ зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд тодруулга өгөх, иргэний нийгмийн байгууллага дүгнэлт хүргүүлэх нь тогтмол биш тул тухайн үйл ажиллагааны давтамж багасгах боломжтой.

3.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Мэдээллийн санд оруулах эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны, ойн баялаг ашиглах үйл ажиллагааны, амьтан агнах, барих үйл ажиллагааны, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн тоог цөөлөх, эсвэл багцлах боломжтой эсэхийг судлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны чиглэл бүрээр хуулийн этгээд нь 6-47 төрлийн мэдээллийг гаргаж өгөх нь мэдээллийн агуулга өргөн байгааг харуулж байна.

3.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төслийн 12.6.1 дэх хэсэгт заасан шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөхөд цахим байдлаар мэдээлэх боломжтой. Мөн Хуулийн төслийн 12.6.5 дах хэсэг болон 20.4 дэх хэсэгт заасан чиг үүргүүдийг тус тус цахим байдлаар мэдээлэх боломжтой байна.

3.6. Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт Хуулийн төсөлд тусгагдсан үүргийн улмаас хуулийн этгээдэд бусад төрлийн нэмэлт зардал гарахгүй гэж тооцоолов.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, хуулийн этгээдэд учрах зардлыг урьдчилан тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Үндэсний зөвлөл, түүний ажлын алба, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад **631,042,416** төгрөгийн зардал гарахаар байгаа бол мэдээлэл нийлүүлэгч төрийн байгууллага бүрд **26,293,434** төгрөгийн зардал үүсэхээр байна. Дээрх зардал нь хуулийн төсөлд тусгагдсан ажил, чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай албан хаагчдын нэг жилд оногдох цалингийн болон материаллаг зардлын нийлбэр юм.

Хуульд дурдсан ажил чиг үүргээс гадна олборлох үйлдвэрлэлийн ил тод мэдээллийн сангийн систем, порталын хөгжүүлэлт, сайжруулалттай холбоотойгоор зардал гарах бөгөөд уг зардлыг энэхүү аргачлалын дагуу тооцоолох боломжгүй байгааг анхаарах нь зүйтэй. Олборлох үйлдвэрлэлийн нээлттэй мэдээллийн сангийн холбогдох төрлүүдийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцах бол Үндэсний зөвлөл, түүний ажлын алба нь дээрх санг холбосон олборлох үйлдвэрлэлийн нэгдсэн порталыг хариуцна. Тус хуулийн төслийн 7, 8, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийн төрийн байгууллагад холбогдох хэсгийг хамгийн багадаа 60 гаруй төрийн байгууллага мэдээллийн санд нийлүүлэх үүрэг хүлээхээр байна. Мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх тул мэдээлэл хүргүүлэх давтамж, тохиолдлын тоо, агуулгыг багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй. Гэвч тусгай зөвшөөрөл олгох хүсэлт гаргах, хүсэлтийг бүртгэх, хүсэлтийн бүрдүүлбэрийг хангах, зөвшөөрөл олгох, цуцлах, түдгэлзүүлэх, холбогдох ил тод байдлын тайлан, мэдээг цахимаар хүргүүлэх боломжтой байдлаар системийг хөгжүүлэх нь олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн ил тод байдлыг хангахаас гадна тухайн процессыг хялбаршуулах, мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангах, нэг төрлийн мэдээллийг хэд хэдэн этгээдэд хүргүүлэхтэй холбоотойгоор төр, иргэн, хуулийн этгээдэд ихээхэн зардал, чирэгдэл учрахаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой байж болохоор байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд дунджаар Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд **699,929,600** төгрөгийн зардал, Иргэний нийгмийн байгууллагад **469,064,400** төгрөгийн зардал тус тус гарах төлөвтэй байна. Нийт зардал **1,168,994,000** төгрөг гарахаар байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуульд тусгагдсан зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоог 5,756, иргэний нийгмийн 17,634 байхаар тус судалгаанд тооцсон. Энэхүү үзүүлэлтийг нийт хуулийн этгээдийн тоонд үндэслэсэн тул мэдээллийн санд мэдээлэл оруулах, ил тод байдлын тайлан гаргах, тодруулга өгөх зэрэг чиг үүргийг хийх хуулийн этгээдийн тоо багасна. Хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүргийн давтамжийг жилд 1 байхаар тусгасан боловч зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд тодруулга өгөх, иргэний нийгмийн байгууллага дүгнэлт хүргүүлэх нь тогтмол биш тул тухайн үйл ажиллагааны давтамж багасах боломжтой.

Мэдээллийн санд оруулах эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны, ойн баялаг ашиглах үйл ажиллагааны, амьтан агнах, барих үйл ажиллагааны, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн тоог цөөлөх, эсвэл багцлах боломжтой эсэхийг судлах

шаардлагатай. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны чиглэл бүрээр хуулийн этгээд нь 6-47 төрлийн мэдээллийг гаргаж өгөх нь мэдээллийн агуулга өргөн байгааг харуулж байна.

Хуулийн төслийн 12.6.1 дэх хэсэгт заасан шаардлагатай тайлбар, тодруулгыг сонирхогч этгээдэд өгөхөд цахим байдлаар хүргүүлэх боломжтой юм. Мөн Хуулийн төслийн 12.6.5 дахь хэсэг болон 20.4 дэх хэсэгт заасан чиг үүргүүдийг тус тус цахим байдлаар мэдээлэх зардлыг бууруулж болно.